УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Увс аймгийн Ерөнхий боловсролын 2 дугаар цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2022/114/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаангом хот<br>2022 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Батсайхан<br>Утас: 70453799, Цахим хаяг: batsaikhanS@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт........................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................
3. Аудитын тайлан ........................................ 9
   3.1 Ерөнхий зүйл ........................................ 12
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт........................................ 12
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................ 12
   3.4 Материаллаг байдал........................................ 13
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........................................ 13
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........................................ 13
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........................................ 15
   3.8 Аудитын гол асуудал........................................ 15
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................ 15
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................ 16
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................ 16
4. Аудитын илрүүлэлт........................................ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................ 16

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.11 № УВА-2022/114/НА-СТА-ОШЗ
танай_____________-ны №_______________-т

АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ч.БАТТОГТОХ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Ерөнхий боловсролын 2 дугаар цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Ерөнхий боловсролын 2 дугаар цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0200200321

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **243,831,788.97** | **268,888,883.27** |
| **33** | **АВЛАГА** | 260,500.00 | 4,525,200.00 |
| **335** | **Бусад авлага** | 260,500.00 | 4,525,200.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 260,500.00 | 4,525,200.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 243,571,288.97 | 264,363,683.27 |
| **351** | **Түүхий эд материал** | 28,797,417.00 | 49,068,640.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 28,677,417.00 | 48,601,840.00 |
| 35130 | Эм боох материал | 120,000.00 | 466,800.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 214,773,871.97 | 215,295,043.27 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 17,938,710.00 | 11,510,235.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,973,400.00 | 6,518,050.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 818,500.00 | 10,906,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 82,200.00 | 4,197,370.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 192,961,061.97 | 182,163,388.27 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,846,161,334.43** | **4,642,190,305.12** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,846,161,334.43 | 4,642,190,305.12 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,338,981,334.43 | 4,135,010,305.12 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,226,959,329.29 | 4,226,959,329.29 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -272,281,044.48 | -447,621,255.48 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 531,945,857.48 | 574,399,860.88 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -352,653,340.60 | -405,807,773.72 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 246,807,527.06 | 251,879,027.06 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -136,527,554.15 | -169,696,504.34 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 17,176,710.40 | 7,774,513.40 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -12,395,811.57 | -3,338,364.97 |
| 39217 | Ном | 89,949,661.00 | 100,461,473.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 507,180,000.00 | 507,180,000.00 |
| 39301 | Програм хангамж | 2,220,000.00 | 2,220,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,220,000.00 | -2,220,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 507,180,000.00 | 507,180,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,089,993,123.40** | **4,911,079,188.39** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,089,993,123.40** | **4,911,079,188.39** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,089,993,123.40 | 4,911,079,188.39 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,900,863,149.78 | 1,900,863,149.78 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,900,863,149.78 | 1,900,863,149.78 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,547,911,844.99 | 2,368,997,909.98 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,547,911,844.99 | 2,547,911,844.99 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -178,913,935.01 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 641,218,128.63 | 641,218,128.63 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,089,993,123.40** | **4,911,079,188.39** |

**Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,814,994,566.26** | **2,857,242,218.30** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **72,509,466.26** | **45,340,092.30** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 72,509,466.26 | 45,340,092.30 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 10,946,174.00 | 115,920.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,946,174.00 | 115,920.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **188,973,900.00** | **401,716,826.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,553,511,200.00 | 2,410,185,300.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10,970,500.00 | 15,257,495.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,800,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,770,500.00 | 10,600,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 200,000.00 | 1,857,495.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 178,003,400.00 | 386,459,331.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 178,003,400.00 | 386,459,331.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,731,955,316.43** | **3,036,156,153.31** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,728,949,116.43** | **2,963,602,576.31** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,728,949,116.43 | 2,963,602,576.31 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,232,352,819.00 | 1,963,007,942.00 |
| 210101 | Үндсэн цалин | 633,865,908.00 | 1,306,295,142.00 |
| 210102 | Нэмэгдэл | 502,309,021.00 | 530,311,700.00 |
| 210104 | Урамшуулал | 96,177,890.00 | 126,401,100.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 153,168,634.00 | 251,074,441.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 97,413,834.00 | 173,083,241.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,887,700.00 | 19,497,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,651,500.00 | 15,598,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,986,600.00 | 4,036,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,229,000.00 | 38,858,800.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 164,317,929.00 | 362,928,131.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,298,199.00 | 12,800,843.00 |
| 210302 | Түлш, халаалт | 148,178,137.00 | 323,640,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,841,593.00 | 26,486,808.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 23,343,826.08 | 49,926,877.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 481,600.00 | 1,272,670.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 118,800.00 | 1,271,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 943,850.00 | 2,816,121.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 51,000.00 | 123,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 583,700.00 | 949,050.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,486,300.00 | 14,232,276.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 18,678,576.08 | 29,262,760.60 |
| **2105** | **Нормативт зардал** | 13,962,945.00 | 36,264,690.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 80,000.00 | 463,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 13,882,945.00 | 35,801,190.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 612,000.00 | 13,619,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 612,000.00 | 13,619,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 1,472,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 1,472,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,421,350.00 | 5,077,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 245,000.00 | 3,067,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 876,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,350.00 | 1,133,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 139,769,613.35 | 280,231,594.71 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,314,910.00 | 18,223,250.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 137,454,703.35 | 262,008,344.71 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,006,200.00 | 72,553,577.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,006,200.00 | 48,404,200.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 2,806,200.00 | 43,931,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 4,472,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 24,149,377.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 24,149,377.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **83,039,249.83** | **-178,913,935.01** |

**Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | | **2,812,018,046.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **115,920.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 115,920.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | | 115,920.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 115,920.00 |
| **124** | **Зээлийн орлого** | | 00.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **2,811,902,126.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | 2,410,185,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 15,257,495.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 2,800,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 10,600,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 1,857,495.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | 386,459,331.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 386,459,331.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | | **2,812,018,046.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **2,812,018,046.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **2,734,939,269.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 1,956,082,605.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 1,299,369,805.00 |
| 210102 | Нэмэгдэл | | 530,311,700.00 |
| 210104 | Урамшуулал | | 126,401,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 257,739,278.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 179,748,078.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 19,497,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 15,598,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 4,036,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 38,858,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 362,928,131.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 12,800,843.00 |
| 210302 | Түлш, халаалт | | 323,640,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 26,486,808.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 38,023,995.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 2,442,695.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1,173,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 2,816,121.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 2,224,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 4,994,379.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 24,373,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | 43,479,260.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 667,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 39,916,360.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 2,895,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 58,451,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 33,770,000.00 |
| 210602 | Тавилга | | 1,150,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 23,531,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 1,472,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 5,077,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 3,067,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 876,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 1,133,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 11,685,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 11,685,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **77,078,777.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 52,929,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 43,931,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 8,998,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | 24,149,377.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 24,149,377.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | | **00.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | | 00.00 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 00.00 |

**Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,270,923,149.78 | 134,391,551.79 | 719,401,354.36 | 2,124,716,055.93 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,270,923,149.78** | **134,391,551.79** | **719,401,354.36** | 2,124,716,055.93 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 629,940,000.00 | 00.00 | 161,256,144.46 | 791,196,144.46 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,900,863,149.78** | **641,218,128.63** | **2,547,911,844.99** | 5,089,993,123.40 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,900,863,149.78** | **641,218,128.63** | **2,547,911,844.99** | 5,089,993,123.40 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,900,863,149.78** | **641,218,128.63** | **2,547,911,844.99** | 5,089,993,123.40 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -178,913,935.01 | -178,913,935.01 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,900,863,149.78** | **641,218,128.63** | **2,368,997,909.98** | 4,911,079,188.39 |

## Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,802,697,800.00 | 2,772,611,174.00 | 30,086,626.00 | 98.93 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,802,697,800.00 | 2,772,611,174.00 | 30,086,626.00 | 98.93 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,752,953,600.00 | 2,725,519,774.00 | 27,433,826.00 | 99.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,964,080,500.00 | 1,956,082,605.00 | 7,997,895.00 | 99.59 |
| 210101 | Үндсэн цалин | 1,307,367,700.00 | 1,299,369,805.00 | 7,997,895.00 | 99.39 |
| 210102 | Нэмэгдэл | 530,311,700.00 | 530,311,700.00 | 0.00 | 100.00 |
| 210104 | Урамшуулал | 126,401,100.00 | 126,401,100.00 | 0.00 | 100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 263,220,800.00 | 257,739,278.00 | 5,481,522.00 | 97.92 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 185,229,600.00 | 179,748,078.00 | 5,481,522.00 | 97.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19,497,800.00 | 19,497,800.00 | 0.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,598,200.00 | 15,598,200.00 | 0.00 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,899,500.00 | 4,036,400.00 | -136,900.00 | 103.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 38,995,700.00 | 38,858,800.00 | 136,900.00 | 99.65 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 368,981,300.00 | 362,928,131.00 | 6,053,169.00 | 98.36 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 18,124,800.00 | 12,800,843.00 | 5,323,957.00 | 70.63 |
| 210302 | Түлш, халаалт | 323,701,100.00 | 323,640,480.00 | 60,620.00 | 99.98 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 27,155,400.00 | 26,486,808.00 | 668,592.00 | 97.54 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 32,292,500.00 | 32,292,500.00 | 0.00 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,215,200.00 | 1,215,200.00 | 0.00 | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,089,200.00 | 1,089,200.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,766,700.00 | 2,816,121.00 | -49,421.00 | 101.79 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,328,300.00 | 1,274,500.00 | 53,800.00 | 95.95 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,696,000.00 | 4,364,379.00 | 331,621.00 | 92.94 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 21,197,100.00 | 21,533,100.00 | -336,000.00 | 101.59 |
| **2105** | **Нормативт зардал** | 51,380,500.00 | 43,479,260.00 | 7,901,240.00 | 84.62 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 667,800.00 | 667,800.00 | 0.00 | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 47,817,600.00 | 39,916,360.00 | 7,901,240.00 | 83.48 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,895,100.00 | 2,895,100.00 | 0.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 56,031,200.00 | 56,031,200.00 | 0.00 | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 32,500,000.00 | 32,500,000.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 23,531,200.00 | 23,531,200.00 | 0.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,472,800.00 | 1,472,800.00 | 0.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,472,800.00 | 1,472,800.00 | 0.00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,936,000.00 | 3,936,000.00 | 0.00 | 100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,926,900.00 | 1,926,900.00 | 0.00 | 100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 876,000.00 | 876,000.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,133,100.00 | 1,133,100.00 | 0.00 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11558000.00 | 11558000.00 | 0.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,558,000.00 | 11,558,000.00 | 0.00 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 49744200.00 | 47091400.00 | 2,652,800.00 | 94.67 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 49,744,200.00 | 47,091,400.00 | 2,652,800.00 | 94.67 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 46,584,200.00 | 43,931,400.00 | 2,652,800.00 | 94.31 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,160,000.00 | 3,160,000.00 | 0.00 | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,802,697,800.00 | 2,772,611,174.00 | 30,086,626.00 | 98.93 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,410,185,300.00 | 2,386,151,843.00 | 24,033,457.00 | 99.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,410,185,300.00 | 2,386,151,843.00 | 24,033,457.00 | 99.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 392,512,500.00 | 386,459,331.00 | 6,053,169.00 | 98.46 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 392,512,500.00 | 386,459,331.00 | 6,053,169.00 | 98.46 |

**Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **15,257,495.00** | **-15257495.00** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **15,257,495.00** | **-15257495.00** | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 9,419,495.00 | **-9419495.00** | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 5,731,495.00 | **-5731495.00** | |
| 210401 | Бичиг хэрэг | | 1,227,495.00 | **-1227495.00** | |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 84,000.00 | **-84000.00** | |
| 210404 | Ном, хэвлэл | | 950,000.00 | **-950000.00** | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 630,000.00 | **-630000.00** | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 2,840,000.00 | **-2840000.00** | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 2,420,000.00 | **-2420000.00** | |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 1,270,000.00 | **-1270000.00** | |
| 210602 | Тавилга | | 1,150,000.00 | **-1150000.00** | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 1,141,000.00 | **-1141000.00** | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 1,141,000.00 | **-1141000.00** | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 127000.00 | **-127000.00** | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 127,000.00 | **-127000.00** | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 5838000.00 | **-5838000.00** | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 5,838,000.00 | **-5838000.00** | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 5,838,000.00 | **-5838000.00** | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 15257495.00 | **-15257495.00** | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 15,257,495.00 | **-15257495.00** | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 2,800,000.00 | **-2800000.00** | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 10,600,000.00 | **-10600000.00** | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 1,857,495.00 | **-1857495.00** | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу аймгийн Ерөнхий боловсролын 2 дугаар цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Ерөнхий боловсролын 2 дугаар цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Увс аймгийн Ерөнхий боловсролын 2 дугаар цогцолбор сургууль нь бүх нийтийн ерөнхий боловсролыг суралцагчдад эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба эрсдэлд суурилсан дотоод аудит хийжээ. Уг аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Ажилтнуудад ур чадварын нэмэгдэл 13.3 сая төгрөгийг дутуу олгосон зөрчил илэрснийг акт тогтоож нөхөн олгуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Ерөнхий боловсролын 2 дугаар цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,036,156.1 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 15,180.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12,144.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймгийн Ерөнхий боловсролын 2 дугаар цогцолбор сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 183,589.0 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 260.5 | 0.0 | |
| Бараа материал | 243,571.3 | 264,363.7 | 20,792.4 |
| Үндсэн хөрөнгө | 4,846,161.3 | 4,642,040.4 | -204,120.9 |
| **Нийт хөрөнгө** | 5,089,993.1 | 4,906,404.1 | -183,589.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 5,089,993.1 | 4,906,404.1 | -183,589.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 5,089,993.1 | 4,906,404.1 | -183,589.0 |

Авлага дансны дансанд 260.5 мянган төгрөгийн ажиллагсадтай холбогдсон авлага байсныг тайлант хугацаанд барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 264,363.7 мянган төгрөг болж 20,792.4 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,642,040.4 мянган төгрөг болж 204,120.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал хасагдсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь 37,021.5 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга, ном худалдан авсан, 21,015.8 мянган төгрөгийг тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг Боловсрол шинжлэх ухааны яамнаас үнэ төлбөргүй шилжүүлж өгснөөр нэмэгдсэн, 9,402.2 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө акталж устгаснаар хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,906,404.1 мянган төгрөг болж 183,589.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн алдагдалтай гарснаас шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,042,247.6 мянган төгрөгөөр буюу 36.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан акталж, устгасан үндсэн хөрөнгө, бараа материал байна.

Нийт зардал өмнөх оноос 1,308,725.0 мянган төгрөгөөр буюу 43 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан цалин, нийгмийн даатгалын шимтгэл зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,978,955.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,978,955.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 176,258.0 мянган төгрөгөөр бууруулж 2,802,697.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, урамшуулал нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,802,697.8 мянган төгрөгийн төсөв батласнаас 2,410,185.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 392,512.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,802,697.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,772,611.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,772,611.2 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 2,800.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 10,600.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,857.5 мянга, нийт 15,257.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэргийн зардалд 1,227.5 мянга, тээвэр шатахууны зардалд 84.0 мянга, ном хэвлэлд 950.0 мянга, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгалд 630.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд 2,840.0 мянга, багаж, техник хэрэгсэлд 1,270.0 мянга, тавилга эд хогшилд 1,150.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,141.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 127.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 5,838.0 мянга нийт 15,257.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Аймгийн Ерөнхий боловсролын 2 дугаар цогцолбор сургуулийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй тул түүвэрт хамруулж Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148, хугацаа хоцроож 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,525.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг аудитын явцад залруулга хийлгэв. Үүнд:

### 4.1 Залруулсан алдаа

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг зөрчин он дамжин хэрэгжиж буй төслийн үлдэгдэл санхүүжилт 4,525.2 мянган төгрөгийг төслийг хариуцан гүйцэтгэж буй 2 багшийн хувийн дансанд шилжүүлж зардлаар бүртгэснийг аудитын явцад залруулж санхүүгийн тайланд авлагаар тусгуулав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян. төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Аймгийн Ерөнхий боловсролын 2 дугаар цогцолбор сургууль | 1 | 4,525.2 | 1 | 4,525.2 | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР /С.БАТСАЙХАН/

2022 оны 02 сарын 22-ны өдөр